



**“ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(ТӨВ АЙМАГ, СЭРГЭЛЭН СУМ)**

2025 он

АГУУЛГА
ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 1-1

1.1	БАЙРШИЛ	1-1
1.2	ХҮЧИН ЧАДАЛ	1-1
1.3	БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	1-1
1.4	ДЭД БҮТЭЦ.....	1-3

**БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ 2-1**

2.1	ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	2-1
2.2	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2-1	
2.3	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-16
2.4	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-19
2.5	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-27
2.6	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	2-34
2.7	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...	2-38
2.8	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-40

ДҮГНЭЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2-1.	БОМТ-ний биелэлтийн тайлангийн зардлын хураангуй	2-1
Хүснэгт 2-2.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	2-1
Хүснэгт 2-3.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	2-16
Хүснэгт 2-4.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	2-19
Хүснэгт 2-5.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	2-27
Хүснэгт 2-6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	2-34
Хүснэгт 2-7.	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт	2-38
Хүснэгт 2-8.	Тайлагнах хуваарь	2-40

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1.	Нисэх буудлын байршил	1-1
Зураг 1-2.	НУБИЭ ХХК-ийн хариуцдаг барилга байгууламжууд	1-2
Зураг 1-3.	Цахилгааны барилга	1-3
Зураг 1-4.	Дулааны станцын байршил	1-4
Зураг 1-5.	Дулааны станц	1-5

Зураг 1-6. Дулааны станцын нүүрс хадгалах талбай	1-5
Зураг 1-7. Гүний 3 худаг	1-6
Зураг 1-8. Ус цэвэршүүлэх байгууламж.....	1-6
Зураг 1-9. Усны химийн дотоод хяналтын лаборатори	1-7
Зураг 1-10. Бохир ус цэвэрлэх байгууламж.....	1-7
Зураг 1-11. Бохир ус цэвэрлэх байгууламжийн лаборатори.....	1-8
Зураг 1-12. Бохир ус цэвэрлэх байгууламжийн гаралтын цэг	1-8
Зураг 1-13. Химийн бодисуудын агуулахын байршил.....	1-9
Зураг 1-14. Химийн бодис хадгалах шүүгээ	1-10
Зураг 1-15. Агуулахад асгаралтын иж бүрдэл болон MSDS хайрцаг байрлуулсан байдал	1-10
Зураг 1-16. Химийн бодисын үлдэгдэл цуглуулах сав	1-10
Зураг 1-17. Бохир ус цэвэрлэх байгууламжийн химийн бодисын агуулах	1-11
Зураг 2-1. Хаврын мод тарилт	2-17
Зураг 2-2. Ногоон байгууламжийн усалгаа хийгдэж буй байдал	2-18

ОРШИЛ

Энэхүү 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулгын хүрээнд боловсруулав.


Энэхүү биелэлтийн тайлан нь 2025 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн эхний жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан юм.

Энэхүү тайланд нисэх буудлын үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг тусгав.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 БАЙРШИЛ

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р (Эрдэнэ-Уул) багийн нутаг дэвсгэрт 1,010.67 га талбайд байрлана.



Зураг 1-1. Нисэх буудлын байршил

1.2 ХҮЧИН ЧАДАЛ

Чингис хаан олон улсын нисэх буудал нь жилд 1,651,000 (олон улсын 1,380,000, орон нутгийн 271,000) зорчигч хүлээн авах хүчин чадалтайгаар төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар нисэх буудал нь жилд 3,000,000 зорчигч хүлээн авах хүчин чадалтай бөгөөд гадаадын 14, дотоодын 5 агаарын тээвэрлэгч компаниуд тогтмол нислэг үйлдэж байна.


1.3 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

НУБИЭ ХХК нь нисэх буудлын дараах барилга байгууламжуудыг хариуцна.

- Аэродром (хөөрч буух зурвас, явгалах зам, перрон)
- Зорчигч терминалын барилга
- Захиргааны барилга
- Агаарын хөлгийн газрын үйлчилгээний барилга
- Гал унтраах авран хамгаалах албаны барилга
- Карго терминалын барилга
- Дулааны станц
- Ус цэвэршүүлэх байгууламж
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Цахилгааны үндсэн өртөөний барилга

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он

- Төлбөр төлөх цэгүүд, аюулгүйн хамгаалалтын постууд
- Дулаан гарааш
- Цэвэр усны худгууд
- Нийтийн эзэмшлийн автомашины зогсоол зэргийг хариуцдаг.



Зураг 1-2. НУБИЭ ХХК-ийн хариуцдаг барилга байгууламжууд

Хөөрч буух зурвас. Хөөрч буух зурвас нь хоёр чиглэлд ашиглагддаг бөгөөд 11 болон 29 гэсэн дугаартай 3600x45 м зурвастай.

Зорчигч терминалын барилга. Барилгажилтын нийт талбай 53,726 м² ба үүний 37,000 м² нь үйлчилгээний зориулалттай ба зорчигч терминалын барилгад олон улсын нислэг бүртгэлийн 30, орон нутгийн 2, хөдөлгөөнт 2 бүртгэлийн цэгтэй байна.

Барилгын фасад нь өндөр чанарын давхар шилэн хийцтэй тул гадна агаарын хэм дотор орон зайн агаарын хэмд нөлөөлөхгүй байхаар хийгдсэн. Шилэн дээвэртэй тул нэг ба хоёрдугаар давхрын танхимуудыг байгалийн гэрэлтүүлгээр гэрэлтүүлдэг.

Зорчигч терминалын барилга нь зорчигчдыг угтах, чиглүүлэх, мэдээллийн үйлчилгээ, тээш хадгалах үйлчилгээ, олсон гэсэн эд зүйлсийг хадгалах, олгох үйлчилгээ болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ зэргийг үзүүлдэг байна.

Агаарын хөлгийн газрын үйлчилгээний барилга. Агаарын хөлгийн газрын үйлчилгээний барилгын нийт талбай 4431.1 м², гараашны хэсэг 2669.5 м², машин угаалга 141 м², засварын хэсэг 484.33 м² байна.

Аврах гал унтраах алба. НУБИЭ ХХК нь ИКАО-ын шаардлагыг хангасан Аврах, гал унтраах хэлтэстэй бөгөөд нисэх буудал дээр болон 8 км-ийн радиуст болсон агаарын хөлгийн гал, осол, зөрчлийн үед хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах үүрэгтэй ажилладаг.

ИКАО-гийн удирдамжид зааснаар гал унтраах багийнхан нь дохиолол хүлээн авснаас хойш харагдах орчны хүрээнд орших, замын нөхцөл сайтай зурвасын дурын хэсэгт 2

минутын дотор, нисэх хөлгүүдийн хөдөлгөөний талбай дах бусад дурын цэгт 3 минутаас бага хугацаанд амжиж хүрэх ёстой. Иймээс ИКАО- гийн удирдамжийн энэхүү шаардлагад нийцүүлэхийн тулд гал унтраах анги нь зурвасын дунд хэсэгт ойрхон, нисэх зурваст хамгийн богино хугацаанд хүрэх боломж бүхий газарт байрлаж байна.

Карго терминалын барилга. Чингис хаан ОУНБ -ын Карго терминалын барилга нь агаарын тээврээр тээвэрлэгдэх экспортын болон импортын карго, шууданг газрын тээвэртэй холбох цогц үйлчилгээг хүргэдэг байна. Нисэх буудал дахь гаалийн газар, түүний хорио цээрийн алба, агаарын тээвэрлэгч авиа компаниуд, гаалийн болон тээвэр зуучлагч компаниудын үйл ажиллагааг нягт уялдуулж иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай үйлчлэхийг зорьж ажилладаг.

Олон улсын болон орон нутгийн нислэгээр тээвэрлэгдэж ирсэн, тээвэрлэгдэж явах бүх төрлийн ачаа, шууданг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаж ачиж буулгах, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах болон хадгалах цогц үйлчилгээг Олон улсын Иргэний нисэхийн байгууллага (ИКАО), Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос (IATA) гаргасан стандарт, заавар, дүрмийн дагуу чанарын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлж байна.

Карго терминалын барилга нь жилд 11,900 тн ачаа, шуудан нэвтрүүлэх хүчин чадалтай бөгөөд аюултай ачааны агуулах экспорт импорт тус бүрт 28 м², үнэт ачааны агуулах экспорт импорт тус бүрт мөн 28 м² талбайтай. Хөргөлттэй агуулах 12 м², хөлдөөгчтэй агуулах 44 м², 40 тн чингэлэг хөргүүртэй (+2+8 °С, -15-25 °С) агуулах 28.1 м², 750-2,500 кг хүртэл хүчин чадалтай 3 сэрээт өргөгчтэй байна.

1.4 ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж хэрэглээ. Нисэх буудал нь 110/10кВ-ын Хөшигт дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг. 110/35/10 кВт-ын Налайх дэд станцаас 119 дүгээр агаарын шугамаар, 220/110/35 кВт-ын Сонгино дэд станцаас 121, 122-р агаарын шугамаар, 110/10 кВт-ын Бөхөг дэд станцаас 139, 140 агаарын шугам гэсэн 3 талын тэжээлтэй. Үндсэн, салбар дэд өртөөнүүд эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд 50-2,250 кВт чадал бүхий дизель генераторуудаар барилгуудыг эрчим хүчээр хангана.



Зураг 1-3. Цахилгааны барилга


Эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд тус дэд өртөө нь 400 кВА чадал бүхий дизель генератороор барилгыг эрчим хүчээр хангана.

Цахилгааны үндсэн дэд өртөөнөөс 10 кВ-ын сүлжээгээр (РТВ, СТ, НР, STP, НГ, VOR/DME, LLZ, GP, FSS, Sky catering, хил гааль, хурдны зам, Монгол шуудан, ангар, карго барилга байгууламжуудыг, 0.4 кВ-ын сүлжээгээр (AMB, GSE, WTP) тэжээх бөгөөд байгууламж бүрт өөрийн бие даасан 10/0.4 кВ-ын болон 0.4 кВ-ын дэд өртөөтэй.

Хүчдэл тасрах, эрчим хүчний системд гэмтэл саатал гарсан үед 50-2,250 кВА чадал бүхий дизель генераторуудаар тухайн барилгын ослын талын хэрэглэгчдийг тэжээнэ. Байгууламжуудын дэд өртөө нь дэлхийд тэргүүлэх эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэгч болох АBB фирмийн хуурай трансформатор, ячейк, хуваарилах самбар, цитээр тоноглогдсон.

Нисэх буудлын барилга байгууламжуудын кабелийн шугам сүлжээнд 50-240 мм хөндлөн огтлол бүхий 80000 метр кабель шугамыг ашиглан 1.8 км инженерийн (тунель) шугам сүлжээгээр цахилгаан эрчим хүчийг түгээж байна.

Дулаан хангамж хэрэглээ. Нисэх буудлын дулаан хангамжийг зорчигч терминалын барилгаас зүүн урд зүгт 4 км зайд байрлах дулааны станцаас хангана. Дулааны станц нь халаалтын улиралд ажиллана. Тус дулааны станц нь SHF14.1.25/150/70-АI загварын тус бүрдээ 14 Мвт-ын хүчин чадалтай буцламгай үет шаталттай ус халаагуурын 3 зуухтай бөгөөд халаалтын улиралд 2 зуух, нөөцөд 1 зуухыг ээлжилж ажиллуулдаг. Дулааны станц нь нисэх буудлын бүхий л барилга байгууламжуудыг дулааны хангадаг.



Зураг 1-4. Дулааны станцын байршил

Дулааны станц нь хашаандаа нүүрс буулгах талбай болон бараа материалын агуулахтай.



Зураг 1-5. Дулааны станц

Дулааны станцын яндангийн өндөр 45 м бөгөөд Багануурын хүрэн нүүрс хэрэглэдэг бөгөөд гэрээт байгууллагаас худалдан авдаг.



Зураг 1-6. Дулааны станцын нүүрс хадгалах талбай

Нүүрсийг салхинд хийсэхээс сэргийлсэн 2 м өндөртэй торон хашаа нь бетон суурьтайгаа нийлээд 3 м өндөр байна.

Зуухны шаталт нь буцламгай үет шатлалттай, нам температурт буцалгадаг байна. Буцламгай үет шатлалттай зуухны технологийн процессоос шалтгаалж үнсээ зуухнаас – шаарга болон уутат фильтрээр гэсэн 2 аргаар зайлуулдаг.

Дулааны станц нь яндан дахь утааны хийг 60,000 м³ цагийн хүчин чадалтай уутат фильтрээр шүүдэг бөгөөд тус фильтр нь техникийн үзүүлэлтээр 99.98% шүүдэг байна.

Усан хангамж. Нисэх буудлын усны эх үүсвэрийг дулааны станцын барилгаас зүүн урд зүгт 4 км зайд байрлах өөрийн эзэмшлийн 3 ш гүний худгаас хангана.



Зураг 1-7. Гүний 3 худга

Нисэх буудалд байрлах ундны усны эх үүсвэрт 100 м, ус цэвэршүүлэх байгууламж 50 м энгийн хамгаалалтын бүстэй.

Ус цэвэршүүлэх байгууламж. Ус цэвэршүүлэх байгууламж нь карго терминалын барилгын хойд талд байрлах бөгөөд замын хойд талд нь цахилгааны үндсэн дэд өртөө байрлана.



Зураг 1-8. Ус цэвэршүүлэх байгууламж

Эх үүсвэрийн 3 гүний худгаас усыг олборлон ус цэвэршүүлэх байгууламжид байрлах түүхий ус хүлээн авах санд усыг хүлээн авч $800 \text{ м}^3/\text{хон}$ хүчин чадалтай механик шүүлтүүрээр шүүж натри гипохлоридын уусмалаар халдваргүйжүүлэн нийт $1,110 \text{ м}^3$ усыг нөөцлөн, MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлагад нийцсэн усыг цэвэршүүлж хадгалах 400 м^3 багтаамжтай 2 ш санд нөөцөлж, 4 өргөлтийн насосоор дамжуулан хэрэглэгчдийг ундны усаар тасралтгүй ханган ажилладаг байна.

Ус цэвэршүүлэх байгууламжийн 1 давхарт механик шүүлтүүр болон тоног төхөөрөмжүүд, зоорины давхарт ус нөөцлөх сангууд, түгээлтийн насосууд байрладаг. Цэвэр ус дамжуулах шугамын урт нь 4,451 м, голч нь 125 мм, хуванцар хоолойтой байна.

Ус цэвэршүүлэх байгууламж дотор НУБИЭ ХХК-ийн ундны усны химийн дотоод хяналтын лаборатори байрлана.



Зураг 1-9. Усны химийн дотоод хяналтын лаборатори

Тус лаборатори нь Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар итгэмжлэгдсэн бөгөөд ундны усанд рН, цахилгаан дамжуулах чанар, ерөнхий хатуулаг, кальци, магний холимог шүлтлэг, нийт шүлтлэг, гидрокарбонат, хлорид, сульфат, нийт төмөр, аммони, нитрат, нитрит, хуурай үлдэгдэл, фосфат, фтор, үлдэгдэл хлор, натри + кали, ууссан хүчилтөрөгч зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлдог байна.

Бохир ус цэвэрлэх байгууламж. Нисэх буудлын хэмжээнд гарч байгаа ахуйн бохир усыг цэвэрлэх цэвэрлэх байгууламжтай бөгөөд бохир ус цэвэрлэх байгууламж нь зорчигч терминалын барилгаас баруун зүгт 800 м зайд аэродромын барилгын хойд талд байрлана.



Зураг 1-10. Бохир ус цэвэрлэх байгууламж

үйлдвэрлэсэн бөгөөд бүрэн автомат удирдлагын системтэй, 2 ш бохир ус өргөх станцтай. Нисэх буудлын барилга байгууламжуудаас гарсан ахуйн хэрэглээний бохир усыг цуглуулах шугам сүлжээний 3.7 км урт, 66 ш хяналтын худагтай, шугам хоолойн голч 50-300 мм, цэвэршүүлсэн бохир усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэх шугам сүлжээний урт 2.2 км, хяналтын (траншейн) худаг 7 ш, шугам хоолойн голч 200 мм байна.

Зөөврийн бохир усыг хүлээн авч механик болон биологийн цэвэрлэгээг хийж MNS 4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартад нийцүүлэн байгальд нийлүүлдэг байна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

Бохир ус цэвэрлэх байгууламж нь үечилсэн зарчмаар ажиллах бөгөөд цэвэрлэх байгууламж нь хоногт 800 м³ бохир ус хүлээн авах хүчин чадалтай ба цагийн дундаж зарцуулалт 33.3 м³, цагийн хамгийн их зарцуулалт 133 м³ байна. Тус цэвэрлэх байгууламж нь бохир усыг 96-98 % хүртэл цэвэрлэх хүчин чадалтай.

Бохир ус цэвэрлэх байгууламжид нисэх буудлын бусад барилга байгууламжуудаас ирж буй бохир усыг хянадаг суурин төхөөрөмжтэй бөгөөд 30 секундйн давтамжтай ирж буй усны бохирдлыг хэмжиж дата мэдээллийг цуглуулдаг байна.

Газрын үйлчилгээний барилгад агаарын хөлгийн бохир соруулдаг 2 ш машин байдаг бөгөөд тухайн машинаар агаарын хөлгийн бохирыг соруулан цэвэрлэх байгууламжинд нийлүүлдэг байна.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн лабораторид 5 нэр төрлийн химийн бодисуудыг ашиглана.



Зураг 1-11. Бохир ус цэвэрлэх байгууламжийн лаборатори

Бохир ус цэвэрлэх байгууламжид механик болон биологийн цэвэрлэгээ хийсний дараа гаралтын усыг MNS 4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартад нийцүүлэн байгальд хаядаг байна.



Зураг 1-12. Бохир ус цэвэрлэх байгууламжийн гаралтын цэг

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

НУБИЭ ХХК нь Говийн марз хайрхан ХХК-тай нисэх буудлын төвийн шугамд холбогдоогүй барилга байгууламжийн бохир усыг зөөвөрлөх гэрээ байгуулсан ба цэвэрлэх байгууламжийн 1-р худаг руу хийдэг.


Химийн бодисын агуулах, хэрэглээ

НУБИЭ ХХК нь нисэх буудалд химийн бодисын нийт 4 агуулахтай бөгөөд нийт 110 нэр төрлийн химийн бодисын ашиглана.

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахын байршил

№	Агуулахын байршил	Зориулалт
1.	Ус цэвэршүүлэх байгууламж дотор	Химийн бодисын агуулах
2.	Бохир ус цэвэрлэх байгууламж дотор	Химийн бодисын агуулах
3.	Аэродромын барилга 1 давхарт	Карбомид болон давсны агуулах
4.	Газрын үйлчилгээний барилгын гадна талд	Мөстөлтийн эсрэг шингэний агуулах

Агуулахуудын байршлыг доорх зурагт харуулав.



Зураг 1-13. Химийн бодисуудын агуулахын байршил

- Усны дотоод хяналтын лабораторийн химийн бодисын агуулах.** Ус цэвэршүүлэх байгууламж дотор байрлах усны химийн дотоод хяналтын лабораторид ашиглах химийн бодисуудыг тус агуулахад хадгалдаг.



Зураг 1-14. Химийн бодис хадгалах шүүгээ

Агуулахад химийн бодисын ХАЛМ, аюулгүй ажиллагааны самбар, анхны тусламжийн самбар, асгаралтын иж бүрдэл зэргийг байрлуулсан.



Зураг 1-15. Агуулахад асгаралтын иж бүрдэл болон MSDS хайрцаг байрлуулсан байдал

Химийн бодисын үлдэгдлийг тусгай саванд хадгалж, Элемент ХХК-д “Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, ландфиллдэх” гэрээний дагуу тээвэрлүүлдэг.



Зураг 1-16. Химийн бодисын үлдэгдэл цуглуулах сав

Лабораторид ашиглах химийн бодисуудын хэмжээ бага учраас химийн бодисын үлдэгдэл бага байна. Тус лабораторид 97 нэр төрлийн химийн бодисыг хадгална.

2. Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн химийн бодисын агуулах. Бохир ус цэвэрлэх байгууламж дотор химийн бодисын агуулахтай. Тус агуулахад 5 нэр төрлийн химийн бодисыг хадгална.



Зураг 1-17. Бохир ус цэвэрлэх байгууламжийн химийн бодисын агуулах

Агуулахад химийн бодисын ХАЛМ, аюулгүй ажиллагааны самбар, анхны тусламжийн самбар, асгаралтын иж бүрдэл зэргийг байрлуулсан.

3. **Карбомид болон давсны агуулах. Аэродромын барилгын 1 давхарт байрлана.** Аэродромын газарт өвлийн улиралд зурвасын цасыг хайлуулах зорилгоор карбомид (кальцийн хлорид) болон техникийн давсыг хэрэглэдэг. 2024 оны байдлаар агуулахад карбомидын үлдэгдэл 45,435 кг байна. Давсны агуулахад гербицидийг хамт хадгална. Зурвасын хог ургамлыг устгах зориулалтаар гербицидийг хэрэглэнэ.
4. **Мөстөлтийн эсрэг шингэн хадгалах агуулах.** Газрын үйлчилгээний барилгын баруун талд мөстөлтийн эсрэг шингэний агуулах байрлана.

Өвлийн улиралд агаарын хөлгийг мөстөлтөөс хамгаалах зорилгоор хэрэглэнэ. НУБИЭ ХХК Мөстөлтийн эсрэг шингэнийг Цэпү констракшн ХХК-аас гэрээний дагуу Type IV Anti-icing Fluid (Cryotech Polar Guard Advance) төрлийн мөстөлтийн эсрэг шингэнийг худалдан авдаг.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1 ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Хүснэгт 2-1.БОМТ-ний биелэлтийн тайлангийн зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал, ₮
1.	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	109,216,700
2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт	39,430,641
3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	35,000,500
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	277,375,065
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	31,454,000
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	12,528,950
НИЙТ ЗАРДАЛ		505,005,856

2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хүснэгт 2-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
Агаарын чанар				
1.		Бохирдуулагч хийн ялгаралтад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ авах.	200,000	-Дулааны станцын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг хянах зорилгоор 2025.02.25-ны өдөр Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газраар Ус халаах зуухны хэмжилтийг хийлгэсэн. Хэмжилтийн дүнгээр NO _x - 540 мг/нм ³ , SO ₂ - 633 мг/нм ³ , CO 72 мг/нм ³ , TSP 511 мг/нм ³ гарсан бөгөөд энэ нь “MNS 5919:2008. Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга” стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байсан. (Хавсралт №1; Хуудас 61)
2.		Утааны яндангийн уутат шүүлтүүрийг тогтмол шалгаж, тогтоосон хугацаанд солих		2024 оны зуны урсгал засвараар Дулааны станцын 1296 ш уутат шүүлтүүрийн уутыг шинэчлэн сольж, зуухны бэлэн байдлыг хангасан. Уутат шүүлтүүрийг солих дундаж ашиглалтын хугацаа 1.5-3 жил байдаг учраас 2025 онд уутат шүүлтүүрийг солиогүй.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
3.	Итгэмжлэгдсэн лабораториор нүүрсний шинжилгээ хийлгүүлэх, нүүрсний чанарын горимд хяналт тавих. Нүүрс дулааны станцын стандартад нийцэхгүй тохиолдолд нүүрсийг солих арга хэмжээ авах	Хөргөлтийн системийн R22 хөргөх бодисыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль		 <p data-bbox="1115 890 2033 1193">2025-2026 оны халаалтын улиралд дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд Багануурын уурхайн нүүрс хэрэглэх бөгөөд "Эн Жи Эм Эй" ХХК-тай нүүрс нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус компани нь хуваарийн дагуу нийлүүлж байна. "Эн Жи Эм Эй" ХХК нь 2025 оны 09 болон 10 сард Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Дулааны IV цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компани түлшний шинжилгээний лабораториор шинжлүүлсэн. Нүүрсний шинжилгээний хариуг хавсаргав. (Хавсралт №2 Хуудас 63-64) Тус шинжилгээний хариугаар $W^{ar}33.4\%$, $A^r 13.1\%$, $V^{daf} 46\%$, $Q^{ad}_b 5497$ ккал/кг, $Q^{ar}_{net} 3371$ ккал/кг байна.</p> <p data-bbox="1115 1230 2033 1289">2025 онд Карго терминалын барилга доторх 3 ш хөлдөөгчийг R410A төхөөрөмжөөр бүрэн сольсон.</p>

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
5.		орчинд ээлтэй хөргөх бодисоор шинэчлэх Хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол хийж, хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах		Хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын судалгаа хийлгэхээр судалж байна.
6.		Хөндлөнгийн итгэмжлэгдсэн байгууллагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийлгэж байх	7,528,950	-Нисэх буудлын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг хянах зорилгоор 2025.10.22-ны өдөр нисэх буудлын гадаад орчноос азотын давхар исэл, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл зэргийг Ногоон титэм ХХК-иар хэмжүүлсэн. Харин РМ 2.5, 10 тоосонцор, нийт тоос зэргийг Хэлт энд Сэфти Солушинс ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. -Хэмжилтийн үр дүн “MNS 4585:2025. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламжаас даваагүй байна. (Хавсралт №3. Хуудас 66-75) -Дуу шуугианы хэмжилтийг мөн 9 цэгт хийлгэсэн бөгөөд зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг буух үед 61.9 дБА, перрон талбай орчим (агаарын хөлгийн хөдөлгүүр асаалттай байх үед) хийсэн хэмжилт 61.6 дБА буюу “MNS 4585:2025. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан, бусад цэгүүдэд даваагүй.
7.		Нисэх буудлын эргэн тойронд мод, бут сөөг тарьж тоосжилт, дуу чимээг бууруулах		2025 онд нисэх буудалд Терминалын замын хойд талд 500 ш мод тарьсан (Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд дэлгэрэнгүй оруулав).
8.		Тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгт жил бүр	660,000	НУБИЭ ХХК нь тээврийн хэрэгслүүдийг тогтмол оношилгоонд хамруулдаг. (Хавсралт №4. Хуудас 77-101)

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
		хуваарийн дагуу хамруулж байх		
9.	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч бодисууд ялгарах	Ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх		2025 онд техник ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл гараагүй.
10.	Агаарын хөлөг	Агаарын хөлөг болон тээврийн хэрэгслүүдэд хэрэглэх шатахууны чанарыг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж байх	625,350	<p>НУБИЭ ХХК нь нисэх буудалд нийлүүлэгдэж байгаа шатахууныг гэрээт байгууллагаас гэрээний дагуу худалдан авдаг бөгөөд нийлүүлэгдэж байгаа шатахууныг Текеномикс Монгол ГХОХК-ийн лабораториор шинжлүүлдэг.</p> 

Шинжилгээний хариуг хавсаргав. (Хавсралт №5. Хуудас 103-116).

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал				9,014,300 ₮
Дуу чимээ				

11.

Онгоц хөөрч буух, явгалах үе болон тээврийн хэрэгсэл, дуу дохио зэргээс дуу чимээ үүсэх

Сонсголыг хамгаалах нийлэг бөглөө 10-20 дБА, чихэвч 20-40 дБА нь дуу шуугианыг багасгаж чаддаг тул хамгаалах хэрэгслийг агаарын хэсгийн ажилчдад шуугиан ихтэй газарт ашиглах замаар ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх. Ажилчдыг сонсгол хамгаалах хэрэгслээр хангаж, тогтмол хэрэглэж хэвшүүлэх

25,000*325
ш= 8,125,000
₮

Дуу чимээ

НУБИЭ ХХК-ийн Газрын үйлчилгээний газрын ажилчид нь агаарын хөлөгтэй ойр ажилладаг. НУБИЭ ХХК-ийн Аюулгүй байдлын хэлтэс нь ажилчдын дуу шуугианы өртөлтийг тодорхойлуулсан.

Тус хэмжилтээр:

1. Хийн компрессор - 127 дБА
2. Талбай нөхөх -110 дБА
3. Онгоц - 99.4 дБА
4. Перрон талбайд - 87.3 дБА
5. Шөнө - 86.7 дБА байсан.



Ажилчдын сонсголыг хамгаалах зорилгоор чихний бөглөө, хамгаалалтын чихэвч зэргийг хэрэглүүлж байна.

Энэхүү чихний бөглөө, хамгаалалтын чихэвч нь –“MNS 5388:2004. “Толгой хамгаалах хэрэгсэл – сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө-чихэвч) – техникийн ерөнхий шаардлага”


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
12.	Дуу чимээний тархалтын зураглал хийх, дуу чимээний менежментийн төлөвлөгөө боловсруулах	-“MNS 6768:2019. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөгдөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага” зэрэг стандартын шаардлагыг хангасан байдаг.	Нисэх буудалд дуу чимээний тархалтын зураглал хийлгэхээр судалж байна.	Нисэх буудал ашиглалтад орохоос өмнө 2017-2018 онд нисэх зурвасын талбайн 75 га талбайг зүлэгжүүлсэн.
13.	Онгоцны замын эргэн тойронд бут сөөг бүхий ногоон зурвас байгуулах			

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
Дуу чимээ, чичиргээний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал			8,125,000 ₮	
Хөрсөн бүрхэвч				
14.		Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалах. Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх, тогтмол хяналт тавих	72,962,000	-Нисэх буудлын төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй талбайг эцсийн байдлаар шийдвэрлэсний дараа тухайн талбайг хамгаалж, ногоон байгууламж байгуулахаар төлөвлөж байна. -Нисэх буудлын хэмжээнд хөрсний эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлэхээр зорьж ажилладаг. Тухайлбал 2025 онд Карго терминалын зүүн талын 170 у/м шороон суваг шуудууг бетон болгон шинэчлэн сайжруулж, 136,16 м ² шороон даланд эко хавтан суурилуулсан. Нийт 440 у/м суваг шуудууг шинэчлэн сайжруулж, 386,16 м ² шороон даланд эко хавтан суурилуулж нисэх буудалд болзошгүй үерийн аюул үүсэхээс урьдчилан сэргийлсэн.
15.	Барилгын үйл ажиллагааны үед хөрсөн бүрхэвч эвдрэх	Нисэх буудлын орчинд төрийн болон бусад байгууллагууд шинээр барилга байгууламж баригдах тохиолдолд (НУБИЭ ХХК барилга барихгүй) хуулсан газрын шимт хөрсийг дахин ашиглах, барилгажилт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх, зүлэгжүүлэх ажилд хяналт, шаардлага тавих		НУБИЭ ХХК нь 2025 онд нисэх буудалд шинээр барилга нэмж бариагүй.
16.		Нисэх буудлын бүтээн байгуулалтын үед эвдэгдэж, орхигдсон		БОННУ-ний тайланд тусгаснаар нисэх буудлын бүтээн байгуулалтын үед эвдэгдсэн 40 га талбай байна. НУБИЭ ХХК нь тус газарт ирэх жилүүдэд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөн судалж байна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
17.		талбайд техникийн нөхөн сэргээлт хийх Нийтийн эзэмшлийн зогсоолд шатах тослох материал асгарсан тохиолдолд шингээж авах тусгай талбай гаргах		Нисэх буудлын терминалын гадаах нийтийн эзэмшлийн зогсоолд ирэх жилд шатах тослох материал асгарсан тохиолдолд шингээж авах тусгай талбай гаргахаар төлөвлөж байна.
18.	Шатах тослох материал болон хог хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох	Захиргааны барилгын хажуу талын ажилчдын автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох (төвлөрсөн хогийн цэг хамт байрлана)		Ирэх жилүүдэд Захиргааны барилгын хажуу талын ажилчдын автомашины зогсоолын талбайг хатуу хучилттай болгохоор судалж байна.
19.		Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг зогсоолын бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах		Асгаралтын иж бүрдлийг нийтийн эзэмшлийн зогсоолд байрлуулахаар төлөвлөж байна.
Хөрсөн бүрхэвч сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал				72,962,000 ₮
Усан орчин				
20.	Газрын доорх усны хэрэглээ хүрэлцэхгүй байх	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх		Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг хавсаргав.(Хавсралт №6. Хуудас 118-122)
21.		Жил бүр ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, Туул голын сав Газрын захиргаатай гэрээ	-	Гэрээг хавсаргав. (Хавсралт №7. Хуудас 124-127)


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
22.		байгуулж, гэрээг дүгнүүлж байх	3,115,400	<p>-Ус ашиглалтын төлбөрийг жилийн эцэст төлдөг учраас 2025 он дуусаад төлнө.</p> <p>-Харин Хаягдал усны дүгнэлтийн дагуу хаягдал усны төлбөрийг улирал тутамд төлж байна. 2025 оны 1-р улиралд 804,000 төгрөг, 2-р улиралд 815,900 төгрөг, 3-р улиралд 1,495,500 төгрөгийг тус тус төлсөн.</p> <p>(Хавсралт №8. Хуудас 129-152)</p> <p>Нисэх буудлын худгууд нь “Хүлээн авах сан”, “Цэвэршүүлсэн ус нөөцлөх сан-F1”, “Цэвэршүүлсэн ус нөөцлөх сан-F2” гэсэн 3 усан сантай. Усан санг 6 сар тутамд цэвэрлэж, ариутгадаг.</p>
23.	Ундны бохирдох	ус Худгийн усан санг тогтсон хуваарийн дагуу угааж цэвэрлэх	-	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
				

Усан сан руу орох ажилчид ариутгасан хувцас хэрэглэл хэрэглэдэг.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
24.	Ус хангамж, цэвэрлэх байгууламжийн	16,000,000	Бохир ус цэвэрлэх байгууламжид 2025 онд Эрсдэлийн үнэлгээ хийлгэхээр төлөвлөсний дагуу 2025 оны 09-р сараас тус ажлыг “Эрхэс сувд ХХК”-иар	 <p data-bbox="1115 831 2033 890">Харин бохир ус цэвэрлэх байгууламжийн худгийн усан санг улирал бүр угааж, ариутгадаг.</p>

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
25.		<p>сүлжээнд эрсдэлийн үнэлгээг хийлгэх</p> <p>Худгийн ойр орчмын талбайг цэвэрлэх, бүртгэл хөтлөх</p>		<p>гүйцэтгүүлж байна. Одоогийн байдлаар тайлан, дүгнэлт нь эцэслэгдэж гараагүй байна. Гэрээг хавсаргав. (Хавсралт №9 Хуудас 154-156). НУБИЭ ХХК-ийн Инженер техникийн газрын Дулаан, ус хангамжийн хэлтэс нь нисэх буудлын 3 гүний худгийг хариуцдаг. Ундны усны аюулгүй байдлыг хангах үүднээс өдөр бүр үзлэг шалгалт хийж шаардлагатай цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна. Их цэвэрлэгээг жилдээ 2 удаа бүх ажилтныг хамруулан эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд хийж ундны усны аюулгүй байдлыг тогтмол ханган ажиллаж байна.</p> 
26.	Худгийн автомат камерт эвдрэл гэмтэл гарснаар худгийн хэвийн	Худгийн автомат камерийн хэвийн тогтмол шалгаж, хэвийн		Худгууд нь бүрэн автомат удирдлагын системтэй. 24 цагийн турш хянадаг. Эвдрэл гэмтэл гарсан үед дуудлага өгч засварлуулдаг.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
27.	үйл ажиллагааг хянах боломжгүй болох	ажиллагааг хангуулах, засвар үйлчилгээг тухай бүрт хийлгэх		
	Гүний хэрэглээ усны	Усны хяналт мониторингийг тогтмол хийх		<p>Нисэх буудлын Ус цэвэршүүлэх байгууламж дотор НУБИЭ ХХК-ийн ундны усны химийн дотоод хяналтын лаборатори байрлана. Тус лаборатори нь Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар итгэмжлэгдсэн бөгөөд ундны усанд рН, цахилгаан дамжуулах чанар, ерөнхий хатуулаг, кальци, магни, холимог шүлтлэг, нийт шүлтлэг, гидрокарбонат, хлорид, сульфат, нийт төмөр, аммони, нитрат, нитрит, хуурай үлдэгдэл, фосфат, фтор, үлдэгдэл хлор, натри + кали, ууссан хүчилтөрөгч зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлдог.</p> <p>Магадлан итгэмжлэгдсэн дотоод хяналтын лаборатори нь “MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартын шаардлагыг хангахын тулд төлөвлөгөөний дагуу долоо хоногт 2-3 удаа ундны усны чанарын хяналтын шинжилгээг хийдэг. Шинжилгээний хариуг хавсаргав. (Хавсралт №10. Хуудас 158-177)</p>
28.		Зорчигч терминалын барилгын дээврийн усыг хуримтлуулах шугам сүлжээг шийдэж, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч, хур борооны усыг		Хур борооны усыг хуримтлуулах зорилгоор Зорчигч терминалын барилгын дээврийн усыг хуримтлуулах шугам сүлжээг шийдэж, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авахаар судалж байна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
		хуримтлуулж, дахин ашиглах		
Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал			19,115,400 ₮	
Амьтны аймаг				
29.		Радар систем судлах, боломжтой бол суурилуулах		
30.	Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх	Нисэх буудлын шувуу, хөхтөн амьтдын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх		Нисэх буудлын шувуу, хөхтөн амьтдын судалгааны ажлыг 2024 онд Биологийн нөөцийг хамгаалах төвөөр хийж гүйцэтгүүлсэн. Уг ажлыг 2 жилд нэг удаа хийлгэх учраас 2025 онд хийгдээгүй.
31.		Шувууд үүрлэхээс сэргийлж байгууламжуудад тор суурилуулах		Энэхүү ажлыг ирэх жилүүдэд хийхээр төлөвлөж байна.
32.		Шувуудыг үргээх ultrasonic төрлийн төхөөрөмж суурилуулж, хянах		Энэхүү ажлыг ирэх жилүүдэд хийхээр судалж байна.
Амьтны аймгийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал				-
Ургамлан нөмрөг				
33.	Аэродрмын талбайг шатааснаас ургамал нөмрөг устах	Ургамлыг жил бүр шатаахгүй байх /багадаа 5 жилд нэг шатааж бусад жил хадах/		Нисэх буудлын хөөрч буух зурвасын 75 га зүлэгжүүлсэн талбайн хог ургамлыг нислэгийн аюулгүй ажиллагааг хангахын тулд хог ургамлыг шатааж байсан. Ирэх жилүүдэд тухайн газарт ургамлан нөмрөгийг шатаахгүйгээр хадаж авч байхаар төлөвлөж байна.
34.		Ургамлын үр цуглуулах, хадгалах журам боловсруулж, ургамал хадахын өмнө ургамлын үр цуглуулах		Ургамлын үр цуглуулах, хадгалах журам боловсруулах ажлыг ирэх жилүүдэд хийхээр төлөвлөж байна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зарцуулсан зардал, ₮	Хэрэгжилт
35.	Зүлэгжүүлсэн талбай талхлагдах	Зорчигч терминалын барилгын хойд талын зүлэгжүүлсэн талбайн ургамлын бүрхэвчид аль болох сөрөг нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх үүднээс тухайн талбай дээр ажилчид болон машин, техник явуулахыг хориглож тэмдэгжүүлэх		Зорчигч терминалын барилгын хойд талын зүлэгжүүлсэн талбайг тэмдэгжүүлэх ажлыг 2026 онд хийхээр төлөвлөж байна.
Ургамлан нөмрөгийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал				-
НИЙТ ЗАРДАЛ				109,216,700 ₮

Тайлбар: Нисэх буудлын 2025-2029 оны БОННУ-ний тайлан 2025.09.25-ны өдөр эцсийн байдлаар батлагдсан учраас сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө болон бусад бүлгүүдэд тусгагдсан зарим ажлуудыг ирэх жилүүдэд хийхээр төлөвлөж байна.

2.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2-3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Зорилт	Арга хэмжээ	Цар хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжилт
1.		Зүлэгжүүлэлт, тарьсан модны арчилгаа	Нисэх буудлын нийт ногоон байгууламж	28,430,641	2025 онд зүлгийн усалгаа, засвар үйлчилгээг гэрээт байгууллагаар хуваарийн дагуу хийж гүйцэтгүүлсэн. Гэрээг хавсаргав. (Хавсралт №1 Хуудас 181-182)
2.	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	Мод тарих	500 ш	11,000,000	“Нисэх хүчин – 100 жил”-ийн хүрээнд нисэх буудлын терминалын барилгын замын хойд талд зам дагуу 500 ш агч мод тарьсан.
3.		Усалгааны систем суурилуулах	32,000 м ² зүлэгжүүлсэн талбай болон	-	Нисэх буудал нь өөрийн эзэмшлийн 3 ш худагтай. Ногоон байгууламжийн усалгаанд усалгааны систем суурилуулахаар судалж байна.
4.	Зүлэг талхлагдахаас сэргийлэх	Санамж байрлуулах	тарьсан модны усалгаа	-	Зорчигч терминалын барилгын автомашины зогсоолын дэргэдэх 32,000 м ² зүлэгжүүлсэн талбайд санамж байрлуулахаар төлөвлөн ажиллаж байна.
Нийт зардал					39,430,641 ₮

Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг угтаж 2025.05.05-ны өдөр 500 ш мод тарьсан.



Зураг 2-1. Хаврын мод тарилт

Мөн нисэх буудлын зүлэгжүүлсэн талбайн усалгааг 2025 онд хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.




Зураг 2-2. Ногоон байгууламжийн усалгаа хийгдэж буй байдал

2.4 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хүснэгт 2-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
1.	Байгалийн гамшигт үзэгдэл	Тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, ажилчдад тогтмол сургалт зохион байгуулах	<p>-Галын аюулгүй байдлын тухай Монгол Улсын хуулийн 17.2.4 дэх заалт, Гал түймэр унтраах дүрмийн 8.2, Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний 3.5-ийн дагуу 2025 онд дараах дасгал сургуулилалтыг амжилттай зохион байгуулсан.</p> <p>-2025.03.26-ны өдрийн нислэгийн цонхтой цагаар Нислэг хөдөлгөөн удирдлагын цамхгийн байгууламжид “Гал унтраах шуурхай төлөвлөгөө”-ний дагуу галын бүлгэмтэй нь хамтран байгууламжид гарсан гал түймрийг унтраах тактикийн дасгал сургуулилалт;</p>   <p>-2025.04.04-ний өдрийн нислэгийн цонхтой цагаар Дулааны станцын байгууламжид “Гал унтраах шуурхай төлөвлөгөө”-ний дагуу галын бүлгэмтэй нь хамтран байгууламжид гарсан гал түймрийг унтраах тактикийн дасгал сургуулилалт;</p>  

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
			<p>-2025.08.19-ний өдрийн нислэгийн цонхтой цагаар Карго терминалын байгууламжид “Гал унтраах шуурхай төлөвлөгөө”-ний дагуу АГУХ-ийн 3-р ээлжийн бие бүрэлдэхүүн галын бүлгэмтэй нь хамтран байгууламжид гарсан гал түймрийг унтраах тактикийн дасгал сургуулилалт;</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>-2025.10.13-ны өдрийн нислэгийн цонхтой цагаар ЗТБ байгууламжид “Гал унтраах шуурхай төлөвлөгөө”-ний дагуу галын бүлгэмтэй нь хамтран байгууламжид гарсан гал түймрийг унтраах тактикийн дасгал сургуулилалт зэргийг тус тус амжилттай зохион байгуулсан.</p> <p>-2025 онд 13,000,500 ₮ зарцуулсан.</p>
2.		<p>Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагажуулах</p>	<p>НУБИЭ ХХК нь “Нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөө”-г дагаж мөрддөг. Мөн “Онцгой нөхцөлийн төрөл зарлах, цуцлах” бүлэгт Нисэх буудалд байгалийн гамшиг тохиодсон үед “КОД-10” зарлаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг дэлгэрэнгүй тусгасан байдаг.</p>
3.		<p>ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж нислэгийн үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог дамжуулан анхааруулга өгч байх</p>	<p>“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын албан ёсны фейсбүүк хуудас “<i>Chinggis khaan international airport</i>” нэрээр байдаг бөгөөд тус хуудсанд цаг үеийн мэдээллийг тогтмол нийтэлдэг бөгөөд ОБЕГ-ын мэдээ, цаг агаарын мэдээг мөн тогтмол нийтэлж байна.</p>

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
4.	Үерийн аюулаас сэргийлэхийн тулд ус зайлуулах үерийн усны суваг шуудууны үзлэг шалгалтуудыг тогтмол явуулж байх, цэвэрлэх	-2025 онд ус зайлуулах суваг шуудуунд 33 удаа үзлэг хийж шаардлагатай цэвэрлэгээ, засвар арчлалтын ажлыг хийсэн.	 <p>CHINGGIS KHAAN INTERNATIONAL AIRPORT 6d · 🌐</p> <p>⚠️ СЭРЭМЖЛҮҮЛЭГ</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 7-ноос 8-ны өдрүүдэд төв аймгийн нийт нутгаар их хэмжээний нойтон цас үргэлжлэн орж, цасан шуурга шуурах тул УЛААНБААТАР-ЧИНГИС ХААН ОУНБ РУУ ЗОРЧИХ АВТО ЗАМД ХАЛТИРГАА ГУЛГАА ҮҮСЭХ, ҮЗЭГДЭХ ОРЧИН ХЯЗГААРЛАГДАХ НӨХЦӨЛ БҮРДЭЖ БАЙГААГ ОНЦГОЙЛОН АНХААРУУЛЖ БАЙНА.</p> <p>ИЙМД ЗОРЧИГЧ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ТА БҮХЭН, АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАЖ, АНХААРАЛ БОЛГООМЖТОЙ ЗОРЧИНО УУ.</p> <p>ЦАГ АГААРЫН ГАМШИГТ ҮЗЭГДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙГ АНХААРУУЛЖ БАЙНА !!!</p>

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
			

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
			

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
			 <p>Sep 6, 2025 47.63930887N 106.8 №</p>

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
			 <p data-bbox="1153 877 2042 1029">-Мөн 2025 онд Карго терминалын зүүн талын 170 у/м суваг шуудууг шинэчлэн сайжруулж, 136.16 м² шороон даланд эко хавтан суурилуулсан. Нийт 440 у/м суваг шуудууг шинэчлэн сайжруулж, 386.6 м² шороон даланд эко хавтан суурилуулж нисэх буудалд болзошгүй үерийн аюул үүсэхээс урьдчилан сэргийлсэн.</p>
5.	Гал түймэр	Гал унтраах багаж, тээврийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалтыг хуваарийн дагуу хийх, хэвийн үйл ажиллагааг хангуулах	<p data-bbox="1153 1029 2042 1189">-Зөөврийн гал унтраагуурыг “MNS 5566:2020. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм” стандартын “НУБИЭ” ХХК-ийн харьяа 11 байгууламж болон тээврийн хэрэгслүүдэд байршуулсан байдаг.</p> <p data-bbox="1153 1189 2042 1340">- “НУБИЭ” ХХК-ийн Галын аюулгүй байдлын дүрмийн дагуу 6.2.7. Байгууламжууд дээр галын аюулгүй байдлын төлөвлөгөөт үзлэгийг жил бүрийн тав дугаар сард, төлөвлөгөөт бус үзлэгийг шаардлагатай тохиолдолд хийж, зөвлөмж өгөх, гарсан дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах; гэсэн заалтын дагуу үзлэгүүд тогтмол хийгддэг.</p>

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах, арга хэмжээ	Хэрэгжилт
			<p>-Жил бүр ГАУС төлөвлөгөөт үзлэг хийж гарсан үл нийцлийг залруулах арга хэмжээ авч ажилладаг. -2025 онд 20,000,000 ₮ зарцуулсан.</p>
6.		Галын аюулын анхааруулга самбарыг ил байршуулах	<p>Нисэх буудалд НУБИЭ ХХК-ийн нийт 11 барилга байгууламжид - Зөөврийн гал унтраагуур – 986; -Галын дотор сарай – 27; -Гадна сарай – 11 ш байдаг бөгөөд жил бүр тэдгээрийн хэвийн ажиллагааг хангуулан ажиллаж байна. -2025 онд 2,000,000 ₮ зарцуулсан.</p>
7.		НУБИЭ ХХК-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлуулж, дагаж мөрдөх	<p>(Хавсралт №1 Хуудас 185-199)</p>
8.		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	<p>НУБИЭ ХХК-ийн ажилчдын ажлын онцлогоос шалтгаалан холбогдох ажилчдад "MNS ISO 13688:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас – Ерөнхий шаардлага" стандартад заасан ажлын тусгай хувцсыг өдөр тутамд өмсөж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулж байна.</p>
9.	Үйл ажиллагааны үеийн осол гэмтэл	Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулах	<p>НУБИЭ ХХК нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг 3 төрлөөр ажлын байран дээр өгдөг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Урьдчилсан зааварчилгаа 2. Анхан шатны зааварчилгаа 3. Давтан зааварчилгаа /Өдөр тутмын зааварчилгаа, ээлжит, ээлжит бус/ <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг ажлын байранд дараах төрлөөр явуулж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шинэ ажилтны сургалт 2. Нийт ажилтны сургалт 3. Нисэх буудлын ерөнхий танилцах сургалт 4. Өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалтууд <p>Сургалтуудын дараа шалгалт авч баталгаажуулдаг.</p>
НИЙТ ЗАРДАЛ			35,000,500 ₮

2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)
1	Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа хийж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авах	НУБИЭ ХХК нь ирэх жилүүдэд хог хаягдлын бүтцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөж байна.	-
2	Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	Хог хаягдлын бүтцийн судалгаа хийлгэсний үндсэн дээр компанийн дотоод хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийг боловсруулан батлуулж, дагаж мөрдөнө.	-
3	Хог хаягдлын үйл ажиллагааны дотоод журам боловсруулж, ажилчдад сургалт зохион байгуулах	НУБИЭ ХХК нь ирэх жилүүдэд хог хаягдлын дотоод журам боловсруулж, үүний дараа ажилчдад сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.	-
4	Бусад хог хаягдлыг гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	-НУБИЭ ХХК нь нисэх буудлын хэмжээнд гарч буй нийт энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж “Элемент медиал” ХХК-тай байгуулсан №334/25 ажил гүйцэтгэх гэрээний дагуу тээвэрлүүлдэг. Гэрээг хавсаргав. -2025 оны 12-р сарын байдлаар энгийн хог хаягдлыг тээвэрлүүлэхэд нийт 54,691,190 ₮ зарцуулсан. Тухайлбал, I сард 5,925,600 ₮, II сард 3,570,900 ₮, III сард 6,099,700 ₮, IV сард 2,386,300 ₮, V сард 4,294,120 ₮, VI сард 4,162,400 ₮, VII сард 6,327,100 ₮, VIII сард 4,483,200 ₮, IX сард 5,460,930 ₮, X сард 7,271,550 ₮, XI сард 4,709,390 төгрөгийг тус тус зарцуулсан (Төлбөрийн баримтыг хавсаргав). (Хавсралт №1-№4. Хуудас 202-343)	Энгийн хог хаягдал 54,691,190 ₮;

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)
5	Батлагдсан маягт болон “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх	Нисэх буудлын 2025-2029 оны БОННУ тайлан 2025 оны 9-р сард батлагдсан тул 2025 онд энэхүү ажил хийгдээгүй. Ирэх жилүүдэд “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд Сэргэлэн сумын Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөж байна.	
6	Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	-Аэродром орчмын аюулгүй бүсэд шувууны хяналтын ойртолтын бүсийн 2025.04.21-ний үзлэгээр тус уулзвар дээр зөвшөөрөлгүй явуулын цайны газар ажиллаж байсан. Цайны газрын эзэдтэй уулзаж үйл ажиллагаа явуулах хориотой талаар шаардлагыг хүргэн агаарын хөлөг шувуутай мөргөлдөх аюул эрсдэлийн талаар тайлбарласан бөгөөд Сэргэлэн сумын Байгаль орчны байцаагч шаардлага тавин нүүлгэн шилжүүлсэн.	



Нүүлгэн шилжүүлсний дараа ойр орчмын хогийн цэгийг цэвэрлэсэн.

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)
			
<p>-Дөрвөн замын уулзвар дээрх үйлчилгээ эрхлэгчдийн автомашин нэвтрэх боломжгүй болгох зорилгоор Дундговийн авто замын хажуугийн ус зайлуулах хөвөө хэсгийг 150у/м шуудуу ухаж татсан.</p>			

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)
 <p data-bbox="1288 989 1825 1133">Jul 25, 2025 19:56:22 47.65213342N 106.87993069E Zuunmod - Buren Road Tov</p>			

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)
	 <p>Jul 25, 2025 20:12:21 47.65222716N 106.87980368E Nergüi Zam Sergelen Төв</p>	 <p>Jul 25, 2025 20:36:1 47.65222823N 106.87978953 Zuunmod - Buren Roa Төв</p>	
	 <p>July 22, 2025 at 2:21:07 PM +47.637153,+106.894848 ±6.90m 115° SE Төв Altitude:1385.1meter Speed:12.3km/h</p>		

НУБИЭ ХХК нь аливаа хяналт үзлэгээр илэрсэн ил задгай хог хаягдал, түүнтэй холбоотой зөрчлийг тухай бүр байгаль орчны мэргэжилтэнд мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авч ажилладаг.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2025 он**

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Нийт зардал (₮)
7	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэгийн нөхцөл байдлыг сайжруулах	НУБИЭ ХХК-ийн хэмжээнд гарч буй аюултай хог хаягдлыг 5 ангилалд хуваан эх үүсвэр дээр түр хадгалж, гэрээт байгууллагад шилжүүлдэг.	-
